



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/288

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу “Их баян бүрд” ХХК (4185781)-ий эзэмшлийн Хэрлэн сумын 5 дугаар баг (Өндөрхаан), Тариаланчид гудамжинд байршилтай үйлчилгээний зориулалттай 839м² газрыг иргэн Тугалдээлт овогтой Зээхийн Наранбат (УХ73112214)-д 49 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Иргэн Тугалдээлт овогтой З.Наранбатын эзэмшил газрын тойм зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Баярхүү)-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн З.Наранбатад үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/27 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ

• 231010510